

## **“МОНГОЛ КООСЭН” ТЕХНОЛОГИЙН КОЛЛЕЖИЙН ОЮУТНЫ ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Оюутны зөвлөл нь тус сургуулийн нийт оюутны сайн дурын үндсэн дээр нэгдсэн оюутны өөрөө удирдах бие даасан нэгж мөн.
- 1.2. Энэхүү дүрэм нь Оюутны зөвлөлийн үндсэн дүрэм тул бүх гишүүд дагаж мөрдөнө.
- 1.3. Оюутны зөвлөл нь аливаа улс төрийн нам эвсэл, шашин болон бусад хөндлөнгийн этгээдээс хараат бус, ашгийн төлөө бус, оюутан, гишүүддээ үйлчилдэг нэгж юм.

### **Хоёр. Оюутны зөвлөлийн зорилго, зорилт**

- 2.1. Оюутны зөвлөлийн эрхэм зорилго нь Оюутны албатай хамтран оюутны хөгжил төлөвшилд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах, мөн оюутны авьяас чадварыг дэмжин хөгжүүлэх, эрх ашгийг хамгаалахад оршино.
- 2.2. Оюутны зөвлөл нь Монгол улсын үндсэн хууль, Дээд боловсролын тухай хууль, МКТК-ийн оюутны ёс зүйн дүрэм болон бусад дүрэм журам, түүнчлэн энэхүү дүрмийг мөрдлөг болгон ажиллана.
- 2.3. Сургуулийн нэр хүндийг өндөрт өргөж, оюутны эв нэгдэл, хүсэл эрмэлзлэлийг илэрхийлнэ.
- 2.4. Оюутны сурч боловсрох, өөрийгөө хөгжүүлэх, төлөвшихөд нь бодит хувь нэмэр оруулна.
- 2.5. Оюутанд чиглэсэн үйлчилгээ, хөнгөлөлт урамшууллын тогтолцоо, нийгмийн хамгаалал, халамжийг дэмжиж, санаачилж ажиллана.
- 2.6. Коосэн сургуулиудын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, эв санааны нэгдэлтэй байна.

### **Гурав. Бүтэц, зохион байгуулалт**

- 3.1. Оюутны зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэх;
- 3.2. Оюутны зөвлөлийн гишүүд нь бүх ангийн төлөөлөл байх бөгөөд сайн дурын үндсэн дээр элсэх;
- 3.3. Оюутны зөвлөлийн дарга, нарийн бичгийн даргыг Оюутны зөвлөлийн гишүүдийн хурлаар, нээлттэй санал асуулгаар сонгох. Сонгуулийг бүх гишүүдийн 80-аас дээш хувийн ирцтэйгээр зохион байгуулах;
- 3.4. Оюутны зөвлөлийн дарга нь Сургуулийн удирдах зөвлөлийн гишүүн байна.
- 3.5. Оюутны зөвлөл нь Оюутны албаны харьяанд үйл ажиллагаа явуулах;
- 3.6. Оюутны зөвлөлийн дотоод зохион байгуулалт болон тухайн хичээлийн жилийн ажлын төлөвлөгөөг Оюутны албаны ажлын төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулна. Төлөвлөгөөг улирлын эхний хоёр долоо хоногт багтаан нийт оюутнуудад мэдээлэх;
- 3.7. Оюутны зөвлөлийн хурлыг долоо хоног бүр тогтмол зохион байгуулна. Хурлын тэмдэглэл тогтмол хөтөлж, хурлаар гаргасан шийдвэр, саналыг Оюутны албанд тайлагнана.
- 3.8. Зайлшгүй шаардлагатай үед зөвлөлийн хурлыг зарлан хуралдуулах;
- 3.9. Оюутны зөвлөлийн хурлаар Оюутны зөвлөлийн асуудлыг шийдвэрлэх, оюутны зөвлөлийн даргыг сонгох, чөлөөлөх асуудлыг шийдвэрлэх.

### **Дөрөв. Оюутны зөвлөлийн эрх**

- 4.1. Оюутны эрх ашгийг хамгаалах зорилготой уялдуулан сургалтын алба, мэргэжлийн тэнхим, сургуулийн захиргаанд санал хүсэлт оруулах;
- 4.2. Оюутны чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, хөгжүүлэх, эв нэгдлийг бэхжүүлэх үүднээс олон талт ажлыг бие даан болон хамтарч зохион байгуулах;
- 4.3. Бусад сургуулийн Оюутны зөвлөлтэй хамтран ажиллах;
- 4.4. Сургуулийн Оюутны албаны төсөвт тусгагдсан зардлыг холбогдох үйл ажиллагаанд захиран зарцуулах;
- 4.5. Оюутны зөвлөлийн үндсэн дүрэмд өөрчлөлт, шинэчлэл, засвар оруулах, хүчингүй болгох, шаардлагатай бол урьдчилан Оюутны албанд танилцуулан, сургуулийн Захирлын дэргэдэх зөвлөлөөр хэлэлцэн батлуулах.

### **Тав. Оюутны зөвлөлийн үүрэг**

- 5.1. Оюутны урлаг, спорт, соёл хүмүүжлийн ажлыг зохион байгуулах, чөлөөт цагийг зөв боловсон, үр ашигтай өнгөрүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг явуулах;
- 5.2. Оюутныг эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны ажилд татан оролцуулах;
- 5.3. Оюутантай холбоотой мэдээ, мэдээллийг цаг хугацаа алдалгүй хүргэх, мэдээллийн оновчтой хуваарилалтыг бий болгох;
- 5.4. Оюутны сурах орчныг бүрдүүлэх, нийгмийн асуудлыг шийдэхэд хувь нэмрээ оруулж, дэмжин ажиллах;
- 5.5. Оюутны зөвлөл нь аливаа үйл ажиллагааг зохион байгуулсан, эсвэл оролцсоны дараа Оюутны албанд тайлагнах;
- 5.6. Ажлаа жил, улирлаар төлөвлөж, хэрэгжүүлэх;
- 5.7. Оюутны сурч боловсрох, өөрийгөө хөгжүүлэхэд үлгэрлэн дагуулах;
- 5.8. Оюутны эв нэгдлийг хангаж, эрх ашгийг хамгаалах.

### **Зургаа. Хариуцлага**

- 6.1. Оюутны зөвлөл нь дүрмийнхээ зорилгод нийцээгүй үйл ажиллагаа явуулсан, ноцтой зөрчил гаргасан бол тус сургуулийн МКТК-ийн холбогдох дүрэм, журамд заасны дагуу хариуцлагыг хүлээлгэнэ.
- 6.2. Оюутны зөвлөлийн гишүүн Оюутны зөвлөлийн хурал болон зохион байгуулж байгаа ажилд удаа дараа оролцоогүй бол Оюутны зөвлөлийн хурлаар хэлэлцэн, Оюутны зөвлөлөөс хасна.